



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№144 /358/

2022.08.16

Цаг үе, үйл явдал

МАНАЙ УЛС ЭХНИЙ ШАТНЫ ТЭМЦЭЭНЭЭС АЛТ, МӨНГӨН МЕДАЛЬТАЙ...



"Олон улсын цэргийн наадам"-ын нэг төрөл "Цэргийн ралли 2022" уралдаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид хоёр дахь удаагаа оролцож байна. Монгол Улсын багийг Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн захирагч хурандаа Ц.Төрмөнх ахалж, дасгалжуулагчаар 011 дүгээр ангийн захирагч хурандаа М.Батдорж ажиллаж байна.

Беларусь, ОХУ, Монгол, Киргиз Улсын баг тамирчид оролцож буй тус тэмцээний нэгдүгээр шат буюу "Хүн нэг бүрийн уралдаан" Увс аймгийн Улаангом сумын нутагт явагдаж амжилттай өндөрлөв. Сугалааны дарааллаар Узбекистан Улсын баг салхийг хагалсан бол ОХУ, Беларусь, Монгол Улсын баг тамирчдаар буухиалсан юм. Багууд урал 4x4, 4x6 болон камаз 4x4, 6x6 загварын хүнд даацын автомашинаар уралдлаа. "Цэргийн ралли 2022"

тэмцээний нэгдүгээр шат "Нэг бүрийн уралдаан"-ы дүнгээр урал, камаз 4x4-ийн ангилалд тэргүүн байрыг Монгол Улсын баг эзэлсэн бол дэд байрт ОХУ, гутгаар байрт Беларусь Улсын багууд тус тус шалгарлаа.

Урал, камаз 4x4 ангилалд тэргүүн байрыг ОХУ-ын баг эзэлж Монгол, Узбекистан Улсын багууд удаалав. Тэргүүн байр эзэлсэн Монгол Улсын багийн чиглүүлэгчээр ахлах дэслэгч Б.Шийрэвноров, жолоочоор ахлах ахлагч Б.Баатархүү, урал, камаз 6x6 ангилалд дэд байр эзэлсэн Монгол Улсын багийн чиглүүлэгчээр ахлах дэслэгч Д.Бямбабаяр, жолоочоор сургагч ахлагч С.Амартүвшин ажиллалаа.

"Цэргийн ралли 2022" уралдааны 2, 3, 4 дүгээр шат Бүгд Найрамдах Тува Улсын нийслэл Кызыл хотод үргэлжилнэ.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 23	🌙 11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌙 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.183.53	3.202.0
EUR 🇪🇺	3.283.0	3.300.0
CNY 🇨🇳	470.50	480.00
RUB 🇷🇺	42.40	57.00
JPY 🇯🇵	23.40	24.37
KRW 🇰🇷	2.32	2.49

ЗУРХАЙ



ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Эд мал арвидна

Наран ургах, шингэх:
05.42-20.13

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Сансар

Суудал: Ус

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.

ИНЖЕНЕРИЙН ЦЭРГҮҮД ХҮМҮҮНЛЭГИЙН ҮЙЛСЭД НЭГДЭВ

Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Тус анги нь Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран "Эрүүл дэлхийн төлөө цусаа бэлэглэгчээ" уриатайгаар цус хандивлах аяныг зохион байгууллаа. Тус аяныг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн маркетингийн олон нийттэй харилцах менежер

Р.Энхтуяагаар ахлуулсан баг зохион байгуулсан бөгөөд цус өгснөөр өөрт гарч болох ач холбогдол, давуу талыг тайлбарлаж, анхны мэдэгдэхүүн өгсөн юм. Амралт, зугаалгын улирал, цар тахлын халдвар ихэссэнтэй холбогдуулан цусны доноруудын хандив буурч, цусны нөөц улс орон даяар багассан энэ үед тус аян оновчтой арга хэмжээ болж чадсан юм. Эрдэнэт



хүмүүний амь насыг аврах, цусаа бэлэглэх хүмүүнлэгийн үйлсэд ангийн офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчид өөрсдийн хүсэлтээр хамрагдсанд Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс талархал илэрхийлсэн бөгөөд "Цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхэд та бидний оролцоо чухал юм.

Эх орноо батлан хамгаалагч эр цэргүүд та бүхэн өнөөдөр 180 хүнд

амьдрал бэлэглэлээ. Бусдад халуун сэтгэлээ зориулж, эрүүл мэнд, амьдрал, хөөр баярыг хамтдаа бэлэглэсэн та бүхний баатарлаг үйлс, хэзээ ч мартагдахгүй, сайн үйлс бүхэн дэлгэрэг" хэмээн онцлоод цэргийн албанд нь өндөр амжилтыг хүсэв.

Дэслэгч Р.БИЛЭГ

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 592,129,086

Эдгэрсэн

Нийт: 563,986,818

Нас барсан

Нийт: 6,444,786

Цахим шууданд

7 ХОНОГТ НЭГ НОМ ...



Зэвсэгт хүчний 013 дугаар анги

Хугацаат цэргийн алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний оюуны цангааг тайлж, царааг нь тэлэх үүднээс "7 хоногт нэг ном" аяныг өрнүүлж эхэллээ. Энэ хүрээнд дайчид 7 хоног бүрийн төгсгөлд уншсан номынхоо талаар бусадтайгаа хуваалцаж, мэдлэг мэдээллээ солилцох юм. Эл боломжийг бүрдүүлэх үүднээс ангийн номын сангаас гадна рот, салбартаа номын буланг нээн ажиллуулж байна. Уг аяныг өрнүүлж буйд байлдагч нар сэтгэл өндөр байгаа бөгөөд уншсан номынхоо тухай тэмдэглэлийг хөтлөх дэвтр захиад амжсан байлдагч



нар ч байна. Өөрийгөө болоод онжавуудаа хөгжүүлэх хүсэл эрмэлзэл, хичээл зүтгэл дүүрэн байгаа байлдагч нартаа томоос том амжилтыг хүсье. Ташрамд

дурдахад хугацаат цэргийн алба хаагчдын санал хүсэлтийн дагуу тун удахгүй англи хэл, монгол бичиг, бийрэн бичгийн сургалтыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

*Зэвсэгт хүчний 013 дугаар анги 2021-2022 оны Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу "Дунд хүчний радио зангилааны хүч хэрэгслээр зангилааны аюулгүй байдлыг хамгаалах нь" сэдвээр тасгийн байлдааны буудлагыг төлөвлөн зохион байгууллаа.

*Ахлагч Л.Бямба-Очир нь Шри Чимойн нэрэмжит 6/12/24 цагийн гүйлтийн 2022 оны Улсын аварга шалгаруулах тэмцээний 6

цагийн гүйлтийн төрөлд 63.800 километр гүйж 3 дугаар байр эзлэн III зэргийн болзол хангалаа.

Ахлах ахлагч Н.УУГАНЦЭЦЭГ

БАЙЛДАГЧ НАРАА ЭРГЭЛЭЭ



Зэвсэгт хүчний 338 дугаар анги



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Цэргийн штабын төлөөлөл, Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын удирдлага Чингэлтэй дүүргээс хугацаат цэргийн албанд татагдан тус ангид алба хааж буй дайчдыг эргэлээ.

Энэ үеэр тэдний алба хааж буй орчин нөхцөлтэй нь танилцаж, уулзалт ярилцлага хийж санал хүсэлтийг нь сонссоны зэрэгцээ хугацаат цэргийн алба хаагчдад дархлаа дэмжих амин дэмийн багц бүхий гарын бэлэг гардуулж, хамт дурсгалын зураг татууллаа.

Дэслэгч Б.ПҮРЭВЛХАМ



ГАР УТАСНЫ ШИНЭ АППЛИКЕЙШН БҮТЭЭЛЭЭ



Зэвсэгт хүчний 189 дүгээр анги

Тус ангийн Программ хангамжийн төв "ЦАХ-ын эрх зүй" гар утсанд зориулсан аппликейшнийг хөгжүүлж "App store", "Google play store"-уудад байрлууллаа.

Тухайн аппликейшнийг Төрийн нууцын зэрэглэлд хамаарахаас бусад төрийн албаны хууль, дүрэм журам болон батлан хамгаалах салбарын хэмжээнд дагаж мөрддөг цэргийн албаны холбогдолтой хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг цахим хэлбэрээр нэгтгэх, ангилан төрөлжүүлж цахим сургалтад ашиглах, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний цэргийн алба, сахилга зохион байгуулалт, төрийн албан

хаагчийн болон офицер, ахлагчийн ёс зүйг дээшлүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан.

Одоогоор тус аппликейшнд Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги, Төрийн албаны тухай хууль, Батлан хамгаалах багц хууль, Монгол улсын цэргийн нийтлэг дүрмүүд, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн ёс зүйн дүрэм, Цэргийн албан хаагчийн хувцас өмсөх дүрэм, Цол олгох журам, Энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах журам зэрэг эрх зүйн баримтуудыг оруулаад байна. Цаашид төрийн болон цэргийн албаны холбогдолтой хууль, эрх зүйн баримт бичгүүдийг саналын дагуу нэмэх боломжтой.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн болон цэргийн албаны холбогдолтой хууль, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх сонирхолтой бүх хүнд зориулан бүтээсэн энэхүү аппликейшнийг та татаж авч ашиглахаас гадна үнэлгээ өгөх боломжтой.

Та бүхнийг уг аппликейшнийг хэрэглэн хууль, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж, өөрийгөө хөгжүүлэх хэрэгсэл болгон ашиглахыг уриалж байна.

Гар утасныхаа "App store", "Google Play Store" программуудын хайх хэсэгт "ЦАХ-ын эрх зүй" гэж бичихэд ЗХЖШ-ын лого бүхий "ЦАХ-ын эрх зүй" аппликейшн гарч ирэх бөгөөд "Google Play Store"-ийн INSTALL, App Store-ийн GET товчийг даран татаж суулгана.

ОЙРЫН ЗАЙН ХОЛИМОГ БУУХИА МАРГААШ ЭХЭЛНЭ



"Олон улсын цэргийн наадам"-ын нэг төрөл болсон "Аравт-2022" олон улсын морин цэргийн уралдааны 130 километр замын алсын зайн марш амжилттай үргэлжилж байна. Энэ сарын 15-ны өдөр ОХУ, Узбекистан Улсын баг тамирчид маршаа амжилттай туулаад барилдсан бол өнөөдөр Бүгд Найрамдах Зимбабве Улс, Монгол Улсын морьтон дайчид барианд

орж ирнэ. Тэгвэл маргааш буюу 8 дугаар сарын 17-ны өдөр баг тамирчдын дунд ойрын зайн холимог буухиагаар явганаар 3.1, Оролцогч орны баг тамирчид ойрын зайн холимог буухиагаар явганаар 3.1, морьтойгоор 4.1 километр замыг туулах бөгөөд маршрутын дагуу байрлах цэгт өгөгдсөн гранат шидэх, саадын зурвас туулах, буудлагын дасгал гүйцэтгэх,

тактикийн ажиллагаа, морины давхилт дунд гранат шидэх зэрэг таван даалгаврыг гүйцэтгэнэ. Сугалаа ёсоор ОХУ, Узбекистан баг тамирчдын гараагаар эхэлж, Зимбабве, Монгол цэргүүдээр үргэлжилнэ.

"Аравт-2022" уралдааны хэвлэл мэдээллийн бүлэг